



**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

**ИТХ-ЫН ДАРГА Ц.ЭРДЭНЭБАТ
2017.09.21**

АГУУЛГА

1. Зохион байгуулсан ажил, үйл ажиллагаа
2. ИТХ-ын хуралдаан
3. ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан
4. Хяналт, шалгалт хийсэн байдал
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ИТХ нь 2017 онд орон нутгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эдийн засаг, нийгмийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах, хурлын хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, үр нөлөөг нь дээшлүүлэх, хурлын төлөөлөгч-иргэдийн харилцаа холбоог эрчимжүүлэх чиглэлээр ажлаа зохион байгуулсан байна.

ИТХ-ын 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах нээлттэй хэлэлцүүлгийг 2017.02.03-ны өдөр зохион байгуулж, 117 иргэн оролцсон байна.



ИТХ-ЫН 1-Р УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАНГ 2017.04.28-НЫ
ӨДӨР 74 ИРГЭНД ТАНИЛЦУУЛСАН.



5-Р САРД 21,22-Р ЗӨРЛӨГИЙН 29 ИРГЭДТЭЙ УУЛЗАЖ САНАЛ ХҮСЭЛТИЙГ НЬ СОНССОН.



“Төлөөлөгчдийн нэг өдөр” өдөрлөгийг 2 удаа зохион байгуулсан.

1-р улиралд “**Мөсний баяр**” тэмцээнд **10** багийн **80** тамирчин, нийт **152** иргэн оролсон.



2-Р УЛИРАЛД “ГАР БӨМБӨГ”-ИЙН ТЭМЦЭЭНД 8 БАГИЙН 64 ТАМИРЧИН ОРОЛЦСОН.



XVII жарны “Алтан унжлагат” хэмээх гал тахиа жилийн сар шинийн баяраар сумын ИТХ-ын шагнал “Хүндэт иргэн” –ээр эрүүл мэндийн төвийн дүн бүртгэгч Д.Цэндсүрэн, “Хүндэт өргөмжлөл”-өөр 3-р сургуулийн багш Б.Мөнхсоёл, Илчлэг-Шивээ УҮГ-ын сантехникийн засварчин Г.Эрдэнэбаатар нар шалгарсан байна.



ИТХ-ын ажлын алба нь 2016 оны баримтыг цэгцлэн байнга болон түр хадгалах хадгаламжийн нэгж 28 ширхэг баримт үүсгэж архивласан байна.



ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНААС ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ДАРААХЬ АЛБАН БИЧГҮҮДИЙГ БОЛОВСРУУЛСАН БАЙНА.



ИТХ, Шивээ-Овоо хувьцаат компанид хүсэлт тавьсаны дагуу сар шинийн баяраар 2-р багийн өндөр настан **Л.Долгорсүрэн**, **Г.Оргүйбат**, **Л.Батчулуун**, 2-р багийн иргэн, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой **У.Түмэндэмбэрэл** нарт 100,0 мянган төгрөгний хүндэтгэл үзүүлсэн.



Сар шинийн баярыг тохиолдуулан 2017.02.22-нд байгууллагынхаа харъяа 2 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн.



ИТХ-ын ажлын алба нь ЗДТГ-ын нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ИТХТ-ийн 2011 оны №22 тоот тогтоолоор батлагдсан “ИТХ-аас тус суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай харилцан, хамтран ажиллах журам”-ыг 5 төрийн бус байгууллагад танилцуулан, мөн журмыг хурал.мн веб сайтад байрлуулсан байна.

Сар шинийн баяраар Монголын улаан загалмайн нийгэмлэгийн “Нигүүлсэнгүй манлай малчин”-аар 2-р багийн малчин В.Оюундэлгэр шалгарсан байна.



Сумын улаан загалмайн анхан шатны хорооноос санаачлан "МАЛЧИДДАА ТУСАЛЪЯ" 14 хоногийн сайн үйлсийн аяныг ИТХ-ын ажлын албатай хамтран 2017.03.13-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Аяны хүрээнд 10 байгууллага хамрагдаж, 23 нэр төрлийн 1988000 төгрөгний бараа материаллаг зүйлс цуглуулан, 77 малчин өрхөд тусламж үзүүллээ.



2017.04.11-НЫ ӨДӨР УРД БОЛОН БАРУУН ГЭР ХОРООЛОЛЫН 5
ӨРХИЙН 23 ГИШҮҮНИЙ АМЬДРАЛТАЙ ТАНИЛЦАН УЗАШХ-С ТУСЛАМЖ
ҮЗҮҮЛСЭН.



ИТХ-ын ажлын алба, “Шивээ- Овоо” ХК-ний төлөөлөн удирдах зөвлөл, “Шивээ- Овоо” ХК, “Илчлэг Шивээ” орон нутгийн өмчит үйлдвэрийн газартай хамтран амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр буюу тонн тутмыг 2000 /хоёр мянган/ төгрөгөөр нүүрс олгох ажлыг комиссийн бүрэлдэхүүн 2017.02.08-ны өдөр 33 өрхөд 86.2 тхоныг олгосон байна.



Мөн ИТХ-ын ажлын алба нь сумын оёдлын үйлдвэрлэл эрхэлдэг иргэдийг Шивээ-Овоо ХК-д уламжлан, уурхайн ажилтануудын зуны нормын хувцас захиалан оёулахаар болсон бөгөөд эхний ээлжинд 100 гаруй ажилтануудын хувцасыг нийлүүлээд байна.

2017.05.12-НЫ ӨДӨР 3-Р АХЛАХ СУРГУУЛИЙН “МӨНГӨН ХОНХНЫ” БАЯРТ ОРОЛЦОЖ
12 –Р АНГИЙН ТЭРГҮҮНИЙ СУРАГЧ Э.АНУБҮЖИНД ТАЛАРХАЛ, ДҮРСГАЛЫН ЗҮЙЛ
ХАДГАЛУУЛАВ.



3-Р СУРГУУЛИЙН БИОЛОГИЙН БАГШ Ч.ДЭЖИДМААГИЙН УДИРДСАН ЭКО КЛУБЫН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ 2017.05.25-НЫ ӨДӨР УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД, ӨӨРСДИЙН КЛУБЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЦААШИД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ ТАНИЛЦУУЛЛАА.



СУМЫН АХМАДЫН ХОРООНООС САНААЧЛАН ЗОХИОН БАЙГУУЛСАН “100 ЭХИЙН ЦАЦАЛ” ӨРГӨХ ЁСЛОЛД ОРОЛЦОН АЗАЙ БУУРАЛ Г.САНДАГДОРЖ, Д.САРАНЦЭЦЭГ НАРТ ТАЛАРХАЛ ХАДГАЛУУЛАВ.



СУМЫН ХЭМЖЭЭНД ЭХ ҮРСИЙН БАЯРААР АЛДАРТ ЭХИЙН 2-Р
ЗЭРГИЙН ОДОНГООР 6 ЭЭЖ ШАГНУУЛСАН БАЙНА.




2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР 4 ТӨРЛИЙН СУРГАЛТАНД 18 ИТХ-ЫН АЖЛЫН АЛБАНЫ АЖИЛТАН БОЛОН ТӨЛӨӨЛӨГЧИД ХАМРАГДСАН БАЙНА.

Сургалт





ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ БОЛОН АЖЛЫН АЛБА НЬ “НУТГИЙН УДИРДЛАГА” СЭТГҮҮЛ, ИТХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА БАРИМТЛАХ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ, ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ, АЖИЛТАНУУДЫН ГАРЫН АВЛАГА НОМООР ХАНГАГДААД БАЙНА.



Эхний хагас жилийн байдлаар иргэний танхимд нэг удаагийн хэлэлцүүлэгт зрхион байгуулагдаж 117 иргэн, 5 төрлийн сургалтанд 92 иргэн, нийт 209 иргэн хамрагдсан байна. Мөн иргэдийн санал гомдлыг хүлээн авах 70546060 дугаарын утас, санал хүсэлтийн хайрцагийг тогтмол ажиллуулж байна.

Иргэний танхимаас мэдээллийг түргэн шуурхай хүргэх үүднээс DRPU Bulk SMS төхөөрөмжийг суурилуулан **80786061** дугаарт утаснаас SMS үйлчилгээг 26 төрлийн мэдээллийг давхардсан тоогоор 5426 өрхөд хүргэсэн.

БАТЛАВ
ИТХ-ЫН ДАРГА

Ц.ЭРДЭНЭБАТ



ШИВЭЭГОВЬ СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
2017 ОНД ИРГЭДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙХ ХУВААРЬ

2017.02.02

Гараг	ХАРИУЦАХ ЭЗЭН					
	Хууль эрхзүй, нийгмийн бодлого, ёсзүйн хяналтын ажлын хороо	Төсөв санхүү, эдийн засгийн ажлын хороо	Дэд бүтэц, тохижилт үйлчилгээний ажлын хороо	ХАА, БО, газар зохион байгуулалтын ажлын хороо	1-р багийн иргэдийн нийтийн хурлын дарга	2-р багийн иргэдийн нийтийн хурлын дарга
Даваа	14:00-16:00					
Мягмар		14:00-16:00				
Лхагва			14:00-16:00			
Пүрэв				14:00-16:00		
Баасан					10:00-12:00	14:00-16:00


ЗДТГ-ын үүдэнд урсдаг дэлгэцээр 44 төрлийн мэдээ, мэдээллийг бүртгэн түгээсэн байна.

Шилэн дансны тухай хуулиар төсвийн мэдээллийг байнга мэдээлж хэвшээд байна.

Шивээговь сумын ИТХ-ын sh.ithural@yahoo.com цахим хаяг, Шивээговь хурал.мн веб сайтад 88 төрлийн мэдээ, мэдээллийг 242 зургийн хамт байршуулан иргэдэд нээлттэй ил тод хүргэж байна



ХОЁР: ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААН, ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ



ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ИРЦ

№	Нэрс	Огноо		
		01.24	04.06	05.30
1	Ц.Эрдэнэбат	+	+	+
2	Ж.Батмөнх	+	+	+
3	Г.Адъяасүрэн	-	+	+
4	Г.Эрдэнэбат	+	+	+
5	Ц.Цэрэн-Очир	+	+	+
6	Ц.Даваасүрэн	+	+	+
7	Ч.Амарсанаа	+	+	-
8	П.Түвшинтогтох	+	+	+
9	П.Сарангэрэл	+	-	+
10	Д.Батзул	+	+	+
11	Л.Амгалан	+	+	+


12	И.Жамъянхорлоо	+	+	-
13	Ө.Баяржаргал	+	+	-
14	Х.Нацагням	+	+	+
15	Б.Гэрэлтуяа	+	+	-
16	Ч.Энхжаргал	+	+	+
17	А.Баасанхүү	+	+	+
18	Ц.Баттулга	+	+	-
19	Д.Дархижав	+	+	+
20	Ю.Алтан-Оргил	+	+	-
21	Э.Бат-Эрдэнэ	+	+	+
		95.2%	95.2%	57.0 %

ГУРАВ: ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНААР ОРОН НУТГИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭР ГАРГАСАН БАЙДАЛ

Хурлын хуралдааны үндсэн хэлбэрийн нэг болох тэргүүлэгчдийн хурлыг 17 удаа хийж, 38 тогтоол гарган хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилласан байна.

ИТХ-ын тэргүүлэгчид 2017 онд орон нутгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эдийн засаг, нийгмийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах, хурлын хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, үр нөлөөг нь дээшлүүлэх, хурлын төлөөлөгч-сонгогчдын харилцаа холбоог эрчимжүүлэх чиглэлээр нийт 39 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

УИХ, Засгийн газар, түүний байгуулагуудаас гарсан хууль, тогтоол, шийдвэр, дээд шатны болон сумын ИТХ-аас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хянан шалгах, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг судлан шийдвэрлэх, сумын эдийн засаг нийгмийн амьдралтай холбоотой асуудлууд хэлэлцэн шийдвэрлэх зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.



ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ИРЦ

№	Нэрс	Нийт	Оролцсон	Оролцоогүй
1	Ц.Эрдэнэбат	17	17	-
2	Г.Эрдэнэбат	17	16	1
3	Д.Батзул	17	14	3
4	П.Түвшинтогтох	17	11	6
5	П.Сарангэрэл	17	13	4
6	А.Баасанхүү	17	16	1
7	Л.Амгалан	17	9	8

ИТХ-ын Тэргүүлэгчид 2017.02.08-ны өдөр 3-р сургууль, 3-р цэцэрлэг, эрүүл мэндийн төв, бүжинхэн бүл цэцэрлэг, Илчлэг-Шивээ орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцан, тэдний санал хүсэлтийг сонсож, тулгарч буй бэрхшээлийн талаар танилцсан.



ДӨРӨВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙСЭН БАЙДАЛ.

ИТХ-ын тэргүүлэгчид нь 2017.03.16-ны өдрийн 9-р хуралдаанаар сумын орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хийгдэх дараах ажлуудад иргэдийн хяналтын бүлгийг томилсон байна.

№	Хяналт тавих ажил	Бүлгийн ахлагч	Гишүүд
1	Сумын орон сууцны 2,3,6,7,8-р байрыг хэрэглээний халуун устай болгох /зураг төсөв, ялтсан бойлуур комоор нь авах, 3,8-р байрны подволын халуун усны шугам тавих / тендерийн үйл ажиллагаанд	ИТХ-ын тэргүүлэгч Г.Эрдэнэбат	ИТХ-ын тэргүүлэгч П.Түвшинтогтох, А.Баасанхүү, 1-р багийн иргэн Ц.Оюунчимэг, Г.Мөнхнасан
2	3-р сургуулийн сантехникийн их засвар тендерийн үйл ажиллагаанд	ИТХ-ын тэргүүлэгч Д.Батзул,	1-р багийн иргэн Жаргалсайхан, 2-р багийн иргэн Г.Эрдэнэбаатар,
3	3-р цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах тендерийн үйл ажиллагаанд	ИТХ-ын төлөөлөгч Ц.Цэрэн-Очир	1-р багийн иргэн Б.Отгонбаатар, Б.Номин-Эрдэнэ

ИТХ-ын ажлын алба нь 3-р сургуультай хамтран тус сургуульд хэрэгжиж буй үдийн цай хөтөлбөрийн хүрээнд 2 удаа “Сүмбэр шүтээн” ХХК-ний үйл ажиллагаанд эцэг, эхийн хөндлөнгийн хяналтыг хийсэн байна.



ТАВ. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Сумын ГХУСАЗЗ хуралдаж, 2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016.12.05-ны өдрийн №45 тоот тогтоолоор даргаар нь ИТХ-ын дарга Ц.Эрдэнэбат, нарийн бичгийн даргаар иргэний танхимын ажилтан Н.Цээпил, гишүүдээр сумын Засаг дарга, 1,2-р багийн Засаг дарга нар, ШОХК-ний хуулийн зөвлөх, 3-р сургуулийн нийгмийн ажилтан, 3-р цэцэрлэгийн эрхлэгч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, сумын залуучуудын холбооны тэргүүн, эрүүл мэндийн төвийн эрхлэгч гэсэн бүрэлдэхүүн томилогдон ажиллаж байна.



ГХУСАЗЗ нь Эрүүл мэндийн төвтэй хамтран 3-р сургуулийн сурагчдын дунд "Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийт 77 сурагч, мөн 6-р ангийн сурагчдын дунд "АРХИ ТАМХИНЫ НӨЛӨӨЛӨЛ" сэдэвт сургалтыг 2017.02.17-ны өдөр зохион байгууллаа. Сургалтын дараа сурагчдын дунд танин мэдэхүйн А.Х.А тэмцээн зохион байгуулахад, 6б ангийн сурагч Ж.Ханддорж тэргүүлсэн байна.

Мөн "Хүчирхийлэл бидний сонголт биш" сургалтыг 2017.04.11-ны өдөр зохион байгуулж 3-р сургуулийн ангийн 60 сурагч оролцсон.



Сумын цагдаагийн хэсэг, ЗДТГ-ын мал эмнэлэг
үржлийн тасаг, эрүүл мэндийн төвтэй хамтран
2017.03.17-ны өдөр төлбөрт тоглоомын газруудын үйл
ажиллагаатай танилцан арга зүйн зөвлөгөө өгөн
ажилласан.



Аймгийн прокурорын газрын дарга **С.Батсүрэн**, аймгийн прокурорын тамгын газрын дарга **Ц.Роза**, цагдаагийн хэлтэсийн олон нийттэй харьцах албаны ахлах байцаагч **Ш.Ариунсан** нарын бүрэлдэхүүнтэйгээр 2017.03.21-ний өдөр сумын ГХУСАЗЗ-ийн 1-р улирлын ажил байдалтай танилцаж “Хангалттай” үнэлгээ өгсөн байна.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн нь 2017.03.28-29-ны өдрүүдэд хөдөөгийн 61 өрхийн малчидтай уулзан, 3 төрлийн гарын авлага, тараах материалыг тараасан байна.



АЙМГИЙН ГХУСАЗСЗ-ӨӨС 2-Р УЛИРАЛД САНХҮҮЖҮҮЛСЭН 500.0 МЯНГАН ТӨГРӨГӨӨР 1-Р БАГИЙН ИРГЭН Н.ЧУЛУУНТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАН СУМЫН ТӨВД 10 ШИРХЭГ ЗАМЫН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГ ЭЭ ХИЙЖ БАЙРШУУЛСАН.



Анхаарал хандуулсан
таньд баярлалаа